

## ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2020 ОНЫ 2 ДУГААР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

### НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлыг 2 удаа зохион байгуулж, 3 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн. Зөвлөлийн хурлаар аймгийн Аварга малчин өрх болон аймгийн Алдарт уяачийг шалгаруулж, эмчилгээний тусламж хүссэн 1 иргэний өргөдлийг хэлэлцэж, эмчилгээний 300.000 төгрөгийн тусламж үзүүлэхээр шийдвэрлэсэн.

Аймгийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж, сумд болон Засаг даргын харьяа хэлтэс, агентлагийн дарга нарт 4 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг хангуулан ажилласан.

2020 оны 02 дугаар сарын 03-28-ны өдрийг хүртэлх хугацаанд аймгийн Засаг даргын Тамгын газрын нийгмийн сүлжээний хуудсанд нийт 43 удаагийн мэдээллийг нийтэлсэн байна.

Шинэ коронавирус /COVID19/ халдвараас урьдчлан сэргийлэх, аймгийн хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, авто зам хаах зэрэг цаг үеийн шуурхай мэдээллийг шууд иргэдэд хүргэх зорилгоор 6 удаагийн мэдээлэл хийж тус мэдээллийг давхардсан тоогоор нийт 27.400 иргэнд хүргэсэн.

Мөн фото зураг болон видео мэдээ, бичвэр бүхий 37 удаагийн мэдээлэл давхардсан тоогоор нийт 77677 удаагийн хандалттай байна.

Шинэ коронавирүсийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн хэмжээнд 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс 03 дугаар сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг зогсоож, олон нийтийг хамарсан соёл урлаг, биеийн тамир, спортын арга хэмжээ, урт, богино, хугацааны сургалт, семинар, дугуйлан семинарын үйл ажиллагааг хориглон, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин ажиллаж байна.

### ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

2020 оны 02 дугаар сарын Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө 146010.6 мян.төгрөг төвлөрүүлэхээс, 372205.3 мян.төг төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 194.3 хувьтай байна.

Орон нутгийн төсвийн байгууллагуудын 1603836.6 мян.төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын 1481480.0 мян.төгрөг, Орон нутаг хөгжил санд 38765.0 мян.төгрөгийн зарцуулалтын эрх төсвийн хуваарийн дагуу бүрэн нээгдэж төрийн сангийн гүйлгээ хэвийн явагдаж байна.

**Статистикийн чиглэлээр:** 2019 оны жилийн эцсийн мал тооллогын ажил дуусч урьдчилсан дүнгээр 452.0 мянган толгой мал тоологдсон.

2020 оны 01 дүгээр сарын нийгэм, эдийн засгийн танилцуулга гаргаж байгууллагын цахим хуудсанд байршуулсан. Хэвлэмэл байдлаар 45 хэрэглэгчид тарааж, цахимаар 150 гаруй хэрэглэгчид хүргүүлсэн.

**Санхүүгийн хяналт, аудитын чиглэлээр:** Төсвийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын 2020 оны 01 дүгээр сарын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгаж байна. Шалгалтын явц 90 хувьтай байна.

**Нийгмийн даатгалын сангаас олгосон: Тэтгэвэр**

№	Төрөл	2019.02.24		2020.02.24		Шинээр тогтоолгосон
		Хүний тоо	Тэтгэврийн дүн /мян, төг/	Хүний тоо	Тэтгэврийн дүн /мян, төг/	
1	Өндөр настан	1654	1270318.8	1748	1514243,0	94
2	Хөгжлийн бэрхшээлтэй	296	161369.0	352	223370,7	56
3	Тэжээгчээ алдсан	123	67130.0	133	82341,1	10
4	Үйлдвэрийн осол	51	50256.0	27	23046,2	-24

**Нийгмийн даатгалын сангаас олгосон: Тэтгэмж**

№	Төрөл	2019.02.24		2020.02.24	
		Хүний тоо	Тэтгэмжийн дүн /мян. төг/	Хүний тоо	Тэтгэмжийн дүн /мян. төг/
1	ХЧТА тэтгэмж	224	10911,3	197	21859,7
2	ЖБА тэтгэмж	41	18802,3	53	818861,2
3	Оршуулга	8	4000,0	9	9000,0
4	ҮОМШӨ-ХЧТА	2	0	0	0
5	Ажилгүйдэл	29	28928,2	42	70798,8
	<b>Нийт дүн</b>	<b>304</b>	<b>62641,8</b>	<b>301</b>	<b>183519,7</b>

**Сайн дурын даатгал:**

Сайн дурын даатгалын хамрагдалт	2019.02.24	2020.02.24
Шинээр	35	58
Мөнгө тушаасан	407	381
Тушаасан мөнгөн дүн / мян төг/	36432,7	42695,9

**ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД****Архивын ажлын чиглэлээр:**

Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд 15 хөмрөгийн 152 хадгаламжийн нэгжийн 161 заалт бүхий 3678 хүний нэр, 834 байгууллагын нэр, 2192 газар зүйн нэр, нийт 7263 хуудас баримтыг цахимжуулж, 573 хуудас баримтыг скайнердан оруулсан байна. Архивын баримтаас 20 иргэнд лавлагаа мэдээллээр үйлчилгээ үзүүлсэн байна.

**Иргэний бүртгэлийн чиглэлээр:**

- Шинээр гадаад паспорт захиалсан -14
- Иргэний үнэмлэх шинээр олгосон -90
- Төрснөө бүртгүүлсэн хүүхдийн тоо- 34
- Гэрлэлт бүртгүүлсэн тоо - 4
- Гэрлэлт цуцлуулснаа бүртгүүлсэн тоо -2
- Овог, нэр өөрчлөлтийн бүртгэлийн тоо -1
- Нас барсныг бүртгүүлсэн тоо - 5
- Өөр аймаг, хотоос шилжиж ирсэн нийт иргэн -71
- Аймаг дотор шилжсэн иргэдийн тоо -64

**Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр:**

- Үл хөдлөх хөрөнгийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 6
- Газар өмчлөх эрхийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 63
- Гэрээний бүртгэл - 37
- Барьцааны гэрээний бүртгэл -298
- Эд хөрөнгөд орсон өөрчлөлт, залруулга -6

**Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр:**

- Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн бүртгэл - 4
- Хуулийн этгээдийн бүртгэлийн өөрчлөлт -4
- Татан буугдсан хуулийн этгээдийн бүртгэл - 1

**Архивын чиглэлээр:**

- Төрийн байгууллагад гаргасан лавлагаа, хуулбар -197
- Иргэнд гаргасан лавлагаа, хуулбар-188-ыг олгож, нийт 385 иргэнд төрийн үйлчилгээг хүргэсэн.

**Цагдаагийн хэлтэс нь:** 2020 оны 02 дугаар сард иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 53 гомдол мэдээлэл ирсэн ба үүнээс гэмт хэргийн 14, зөрчлийн шинжтэй 39, зам тээврийн ослын шинжтэй 1 гомдол мэдээлэл бүртгэгдсэн байна.

“Ятгах тусам нягтал” нэгдсэн арга хэмжээний хүрээнд залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг бүхий календарь 250 ширхэг, компьютерийн хулганы дэвсгэрийг аяны логогоор 100-г бэлтгэн иргэд, аж ахуйн нэгжүүдэд тараасан.

“Гадна талын гэрэлтүүлэх хэрэгсэл” хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд 39 жолоочийг 670.000 төгрөгөөр торгон, 23 жолоочийн зөрчлийг засуулж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 1 жолоочийг илрүүлэн арга хэмжээ авч ажилласан.

Аймгийн хэмжээнд “Сар шинэ 2020”, “Нуугдмал”, “Нэг сэтгэл-Нэг соёл” зэрэг нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж байна.

“Сар шинэ 2020” нэгдсэн арга хэмжээний хүрээнд А0101 хатуу хучилттай авто замд эргүүл, хяналт шалгалтыг тогтмол хийж иргэд, жолооч нарт анхааруулга сэрэмжлүүлэг материал тарааж, тээврийн хэрэгслийн дотор талд анхааруулах наалт наасан. Мөн Баянтал, Шивээговь сумын нутгаар дамжин өнгөрдөг Босоо тэнхлэгийн А/0101 А/0102 авто замд зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хяналт шалгалтаар өдөр бүр 15-21 цагийн хооронд хөдөлгөөнт эргүүлийн хуваарь гарган ажиллаж байна.

Хүн амыг болзошгүй аюулт өвчнөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Цагдаагийн хэлтсийн нийт бие бүрэлдэхүүнийг 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 09:00 цагаас 03 дугаар сарын 02-ны өдрийн 09:00 цаг хүртэл өндөржүүлсэн бэлэн байдлын хоёрдугаар зэрэглэлд шилжүүлэн штаб байгуулан ажилласан.

Аймгийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/56 дугаар захирамжийн дагуу гудамж, талбай, олон нийтийн газрууд, иргэд олноор бөөгнөрч болзошгүй газруудад эргүүлийн чиглэл, маршрутын дагуу өдөр бүр хяналт тавин ажилласан бөгөөд илэрсэн зөрчилгүй.

Мөн Аймгийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/63 дугаартай “Хяналтын цэг байгуулах тухай” захирамжийн дагуу нийт 11 постонд 11 алба хаагч, бусад байгууллагын ажилтнуудын хамт 24 цагаар, эргүүлийн 5 чиглэлд үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.

**Шүүхийн шинжилгээний алба нь:** Хэргийн газрын үзлэгт 18 удаа оролцсоноос зам тээврийн ослын 2, хулгайлах гэмт хэрэг 2, бусад хэргийн газрын үзлэгт 6 удаа оролцож, хэргийн газраас гарын мөр 1, гутлын мөр 20, тээврийн хэрэгслийн мөр 2, бусад ул мөр эд мөрийн баримт 6-г илрүүлэн бэхжүүлж хэргийн материалд хавсаргасан. Хэргийн газрын үзлэгийн болон эд мөрийн баримт, эрэн сурвалжлах, танин олуулах ажиллагаа, хэргийн газрын давтан үзлэг, нэгжлэг, цогцос задлан шинжлэх зэрэг ажиллагааны 222 кадр гэрэл зургийг боловсруулан холбогдох материалд хавсаргасан.

Мөн криминалистикийн 2 шинжилгээг хийж дүгнэлтийг гаргасан.

Тайлант хугацаанд хүний биед гэмтлийн зэрэг тогтоох үзлэг 18 удаа хийж дүгнэлт гаргасан.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-425 дугаар нээлттэй хорих анги нь:** 2020 оны 02 дугаар сард төлбөрийн 14 гүйцэтгэх баримт бичгээс 13 гүйцэтгэх баримт бичгийн 102.837.203 төгрөг, 1 хүүхдийн тэтгэлгийн баримт бичгийг бодитой биелүүлж гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 11 хувьтай байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд бетон арматурчин мэргэжлээр 12, гагнуурчин мэргэжлээр 15, аймгийн Уул уурхайн жишиг сургууль Политехникийн коллежид Хүнд машин механизмын операторчин мэргэжлээр 12, хүнд машин механизмын засварчин мэргэжлээр 14 хоригдлыг сургаж байна.

Шинээр ирсэн 8, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис хууль бусаар ашигласан 15, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмт хэрэг үйлдсэн, архины хамааралтай 59, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 4, ажлын заалтгүй 96, давхардсан тоогоор нийт 580 хоригдолд амьдрах ухаан, гадаад хэл, хөгжим, Монгол бичгийн сургалтуудад хамруулсан.

**Мэргэжлийн хяналтын газар нь:** Улсын онцгой комиссын шийдвэрийн хүрээнд шинэ төрлийн коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангуулах зорилгоор Эрүүл мэндийн хяналтын улсын байцаагчид аймгийн Нэгдсэн эмнэлэг, Шивээговь, Баянтал сумд болон Энх тус дэм өрхийн эрүүл мэндийн төвд шалгалтыг хийж илэрсэн дутагдлыг арилгуулахаар 21 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлж дутагдлыг арилгуулж ажилласан.

Мэргэжлийн байгууллагаас гаргасан зөвлөмж, сэрэмжлүүлгийг иргэдэд дараах байдлаар түгээсэн. Үүнд:

- 92 төрлийн зөвлөмжийг 318 удаа;
- 29 төрлийн сэрэмжлүүлгийг 129 удаа;

- Хот хоорондын нийтийн тээврийн хэрэгслээр зорчигчдод COVID-19 вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор боловсруулсан 11 төрлийн зөвлөмжийг 295 иргэнд;
- Нийтийн тээврийн ААН-д зориулан боловсруулсан мэдэгдлийг 23 байгууллагад;
- Шашны байгууллагуудад олон нийтийг хамарсан шашин номын хурал, цуглаан, зан үйл зохион байгуулахгүй байх тухай мэдэгдэл болон зөвлөмжийг 120 иргэнд;
- Сургалтын боловсролын байгууллагын үйл ажиллагаа эхлэхээс өмнө сургалтын орчны эрүүл ахуй, хоол хүнсний аюулгүй байдлаас шалтгаалсан үүсч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг 17 байгууллагад;
- Сургалтын боловсролын байгууллагын үйл ажиллагааг түр зогсоосонтой холбогдуулан хүүхдийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр зөвлөмж, сэрэмжлүүлэг боловсруулж байгууллагын цахим хуудсаар иргэдэд 3 удаа;
- Хүний биеийн халууныг хэмжихэд ашиглаж буй хэмжих хэрэгслийн ашиглалтын зөвлөмжийг боловсруулж 84 ААН-д тус тус хүргүүлсэн.

Үндэсний уламжлалт сар шинийн баярын үед хүнсний аюулгүй байдлыг хангуулах зорилгоор урьдчилан сэргийлэх шалгалтыг худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээний 27 газарт 02 дугаар сарын 03-17-ны өдрүүдэд зохион байгуулсан. Шалгалтын явцад хүнсний худалдаа үйлчилгээнд зориулалтын бус болон эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл олгоогүй газар, цэгт (мах, сүү, цагаан идээ) худалдаа, үйлчилгээ эрхэлж буй зөрчил 18, мах махан бүтээгдэхүүн, сүү, өндөгний гарал үүслийн гэрчилгээ, баталгаажилтгүй 12 зөрчлийг илрүүлж, зөрчлийг 100 хувь арилгасан. Ил задгай худалдаа хийж байсан 18 иргэнд мэдэгдэл хүргүүлж, худалдааг бүрэн зогсоож, сав баглаа боодлын зориулалтаар ашиглах, худалдахыг хориглосон нимгэн нийлэг уут болон хадгалалт, хэрэглээний хугацаа хэтэрсэн, хаяг шошгоны зөрчилтэй 8 нэр төрлийн 509 ширхэг 1038070 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг улсын байцаагчийн 12 актаар хураан авч орон тооны бус зөвлөлд шилжүүлээд.

Хими нян судлалын лабораторид хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч, эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч болон аж ахуй нэгж байгууллага, иргэний хүсэлтээр ирүүлсэн усны 10, гурилан бүтээгдэхүүний 5, хоолны 2, мах, махан бүтээгдэхүүний 1, будааны 4, хүнсний ногооны 4, жимсний 3, ариутгалын бодисны 3, нийт 32 сорьцод 2-9 үзүүлэлтээр хими, нян судлалын шинжилгээг хийж гүйцэтгэсэн. Эерэг сорьц 2 илэрсэн.

**Онцгой байдлын газар нь:** Аймгийн Онцгой комисс коронавирусын халдварт өвчинтэй холбогдуулан 4 удаа хуралдаж, шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах үйл ажиллагаанд салбар дундын хамтын ажиллагаа, оролцоог хангах, мэдээ мэдээллийг нэгтгэх үндсэн чиг үүрэг бүхий аймгийн шуурхай штаб, гамшгаас хамгаалах 12 албадад тус бүр шуурхай штаб байгуулан ажиллаж, байгууллага, хуулийн этгээд, иргэдэд ариутгал халдваргүйтгэл хийх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сэрэмжлүүлэг мэдээлэл хүргэх зэрэг ажлыг зохион байгуулахыг аймгийн онцгой комиссоос үүрэг болгон ажиллаж байна.

Монгол Улсын Шадар Сайдын баталсан гэр хорооллын айл өрхүүдийн галын аюулгүй байдлыг хангуулах төлөвлөгөөт хяналт шалгалт явуулах удирдамжийн дагуу Сүмбэр, Шивээговь сумын 4 багийн нийт 894 айл өрхөд хяналт шалгалт хийж, 637 зөрчил илрүүлэн, 333 зөрчлийг газар дээр нь арилгуулж, 304 зөрчил дутагдлыг эргэн шалгах хугацаатай үүрэг чиглэл өгч, 3681 хүнд галын аюулаас урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгаа хийж, зөрчлийг арилгуулахаар заавал биелүүлэх албан шаардлага 4, танилцуулга 2-ыг тус тус бичиж хүргүүлэн хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллалаа.

Мөн 8 аж ахуй нэгж байгууллагад гамшиг осол болон гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт хийж, давхардсан тоогоор гал түймэр гарч болзошгүй 25 зөрчил илрүүлж, газар дээр нь 9 зөрчлийг засуулж, Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 2-ыг, мэдэгдэл 1-ийг, танилцуулга 1-ийг тус тус бичиж холбогдох албан тушаалтанд хүргүүлэн, эрх бүхий албан тушаалтнуудад байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт тавьж ажиллаж байх талаар мэргэжил, арга зүйн заавар, зөвлөмжийг өгч ажилласан.

Гал унтраах тархалтын сургуулийг “Нью энерги стар ШТС, “Магнай Трейд ХХК” ШТС, Гор газ ШТС-ын түгээгүүрийн хэсэгт гарсан гал түймрийг унтраах талаар сургалтыг хамтран зохион байгуулсан.

Гал унтраах тархалтын сургуульд гал унтраах ангиас 25 алба хаагч, аж ахуй нэгж байгууллагаас 18 ажилтан албан хаагч хамрагдан тактик, техникийн алдаа дутагдалгүй ажилласан.

2 дугаар сард аймгийн хэмжээнд гал түймрийн 3 удаагийн дуудлага бүртгэгдэж гал түймэр унтраах аврах 37 дугаар ангийн бие бүрэлдэхүүн 2 удаагийн гал түймэр дээр гал унтраах байлдааны тархалт хийж 6.8тн ус, 99 литр шатахуун зарцуулан, гал түймрийн аюулд иргэдийн 44 сая төгрөгийн өмч, хөрөнгө гал түймэрт өртөж шатсан хохирол учирч, 60 сая төгрөгийн өмч хөрөнгийг галын аюулаас авран хамгаалсан байна.

### **ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

**Боловсролын чиглэлээр:** “Боловсролын чанарын шинэчлэл” төслөөр сургуулийн дотуур байранд 1-5 дугаар ангийн сурагчдад унших номыг санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. Төслөөс боловсруулсан каталогийн дагуу номын сонголтын саналыг нэгтгэн төслийн газар хүргүүлээд байна.

**Биеийн тамир, спортын чиглэлээр:** Идэвхтэй дасгал хөдөлгөөнийг амьдралын хэвшил болгох, иргэн бүрийг 30 өдөрт 30 минут идэвхтэй хөдөлгөөн хийж хэвшүүлэх, албан байгууллагуудад ажлын байрны дасгал хөдөлгөөнийг хийж хэвшүүлэх зорилгоор “Идэвхтэй хөдөлгөөн-Эрүүл амьдрал” аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулсан. Тус аянд 10 байгууллагын 177 албан хаагч хамрагдаж, гарын эспандер 32 ширхэг, гарын авлага 226 ширхэгийг тараан ажилласан.

**Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр:** Аймгийн “Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл”-ийн 2020 оны анхдугаар хурлыг 02 сарын 18-ны өдөр зохион байгуулсан. Хурлаар “Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл”-ийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, шинэ төрлийн корона вирусаас урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажил зохион байгуулах, аймгийн хэмжээний 18-40 хүртэл насны залуучуудын шинэчилсэн бүртгэл судалгааг хийх зэрэг ажлуудыг хэлэлцэн баталсан юм.

Уул уурхайн жишиг сургууль политехник коллежийн албан хаагчдад 2020 оны 02 сарын 05-ны өдөр байгууллагын хамт олны эерэг уур амьсгал, эерэг харилцааг бэхжүүлэх, сэдэлжүүлэх зорилгоор “Баг хамт олны хөгжил” сэдэвт сургалт зохион байгуулсан. Сургалтад нийт 31 албан хаагч хамрагдсан.

Аймгийн Засаг даргын 2017 оны А/29 дүгээр захирамжаар байгуулагдсан "Аймгийн хүүхдийн төлөө зөвлөл"-ийн 2020 оны анхдугаар хурал зохион байгуулсан. Тус хуралд нийт 14 гишүүн хамрагдсан бөгөөд зөвлөлийн 2019 онд хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг хэлэлцэж 2020 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 5 чиглэлээр 52 үйл ажиллагааг төлөвлөн баталлаа.

**Соёл, урлагийн чиглэлээр:** Аймгийн Боржигин өв музей, Нийтийн номын сан хамтран Соёлын баримтат өвийг хамгаалах үндэсний хөтөлбөрийн хүрээнд “Соёлын баримтат өвийн хадгалалт хамгаалалт, бүртгэн баримтжуулалт “ сэдвээр соёлын ажилтнуудыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулав. Сургалтад Музей, Номын сан, Боржигин чуулга, сумдын Соёлын төвүүд, ерөнхий боловсролын сургуулийн номын санч, иргэдийн төлөөлөл нийт 30 хүн хамрагдсан.

#### **Эрүүл мэндийн чиглэлээр:**

Үзүүлэлт	2019 оны 02 сар	2020 оны 02 сарын 20-ны байдлаар
Төрсөн эх	67	63
Гэрийн төрөлт	0	0
Амьд төрсөн хүүхэд	67	64
Амьгүй төрөлт	0	0
Нас баралт	3	6
Эмнэлгийн нас баралт	2	0
Хоног болоогүй нас баралт	0	0

0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	2	0
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	0	0
Эмнэлгээс гарсан хүний тоо	874	784
Амбулаторийн үзлэг	17351	14434
Халдварт өвчин	29	17

Аймгийн Онцгой комиссоос шийдвэрлэсэн 3.9 сая төгрөгийн санхүүжилтээр эрүүл мэндийн байгууллагуудад шаардлагатай байгаа амны хаалт, пульсоксиметр, биеийн халуун хэмжигч, ариутгал халдваргүйтгэлийн бодисыг авч эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилсан.

Шинэ коронавирустээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулж, нийт 2068 хүн хамрагдсан. Эрүүл мэндийн байгууллагууд байгууллагын цахим хаягаар шинэ коронавирусын халдварын шинэчлэгдсэн мэдээллийг тогтмол хүргэж байна.

Аймгийн Авто тээврийн үндэсний төв, Цагдаагийн хэлтэстэй хамтран 2020 оны 2 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн хот хоорондын зорчигч тээврийн хэрэгслээр зорчиж буй зорчигчдын эрүүл мэндэд хяналт тавьж, шинэ коронавирусийн халдвараас сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны гарын авлагыг тарааж ажиллаж байна.

Эрүүл мэндийн газраас 2 мэргэжилтэн томилогдон бүх шатны эрүүл мэндийн байгууллагад “Хамгаалах хувцас өмсөж, тайлах дараалал”, “Шинэ кронавирусийн халдварын сэжигтэй өвчтөнөөс лабораторийн сорьц цуглуулах, хадгалах, тээвэрлэх тухай, Шинжилгээний сорьц зөөвөрлөх журам”-ын талаар эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн нийт 75 ажилтанд ажлын байрны сургалт зохион байгуулав.

Тайлант хугацаанд хөдөөгийн баг болон отрын бүсэд амьдарч байгаа малчин өрхүүдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүллээ. Нийт 157 өрхөөр орж үзлэг хийснээс эрсдэлтэй бүлгийн гишүүдийг танилцуулбал:

дд	Эрсдэлтэй бүлэг	сумд									БҮГД
		Сүмбэр			Баянтал			Шивээговь			
		Харьяа лалтай	Гадны	Дүн	Харьяа лалтай	Гадны	Дүн	Харьяа лалтай	Гадны	Дүн	
1	Жирэмсэн	8	2	10	0	0	0			0	10
2	0-5 настай	24	10	34	0	2	2	3	2	5	41
3	65-с дээш насны	16	3	19	0	0	0	6	1	7	26
4	Хөгжлийн бэрхшээлтэй	11	0	11	1	0	1	1	0	1	13
5	Архаг суурь өвчтэй	19	4	23	0	0	0	3	1	4	27
ДҮН		78	19	97	1	2	3	13	4	17	117

**Хөдөлмөр, халамжийн чиглэлээр:** Тайлант хугацаанд 12 ажил олгогчоос 18 төрлийн нийт 38 сул орон тоонд ажлын байрны захиалгыг хүлээн авч, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, 53 иргэнд ажлын байрыг санал болгож ажилласнаар 16 иргэнийг байнгын ажлын байранд зуучилсан.

2018, 2019 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 47 иргэнээс төслийн хэрэгжилтийн үйл ажиллагааны явцын сарын тайланг хүлээн авч, арга зүйн зөвлөгөө өгч, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтөд хяналт тавьж ажилласнаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 39 иргэнээс 33386,5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн.

Сар шинийн баярыг тохиолдуулан аж ахуй нэгж байгууллагад харьяалалгүй 524 ахмадад 5240,0 мянган төгрөгийг олгохоос 408 ахмад настан баримтаа бүрдүүлэн өгч арилжааны банкууд руу 4080,0 мянган төгрөгийн олголтыг илгээсэн. Мөн сар шинийн баярыг тохиолдуулан насны хишгийн үйлчилгээ 634 ахмад настанд 53520,0 мянган төгрөгийн олгосон.

#### **ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

**Мал, аж ахуйн чиглэлээр:** Аймгийн өвс, тэжээлийн аюулгүй нөөцөд өвс 80тн, тэжээл 26.2 тн тэжээл байна.

Аймаг дундын Малх отрын бүсээс гадна 40 өрхийн 40767 толгой мал отроор өвөлжиж байна. Үүнээс Баянтал суманд 5 өрхийн 5219 толгой мал, Сүмбэр суманд 26 өрхийн 28841 толгой мал, Шивээговь суманд 9 өрхийн 6707 толгой мал тус тус оторлож байна.

Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн нэрэмжит шагнал “Алтан тугалын эзэн”-ээр 1, “Алтан ишигний эзэн”-ээр 2, “Алтан хурганы эзэн”-ээр 2 малчныг тус тус шагнуулахаар холбогдох материалыг хүргүүлсэн.

Аймгийн аварга малчин өрх шалгаруулах журмын болзол хангасан 10 малчин өрхийн материалыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн. Үүнд: Сүмбэр сумаас 7 малчин өрх, Баянтал сумаас 2 малчин өрх, Шивээговь сумаас 1 малчин өрх тус тус аймгийн “Аварга малчин өрх”-өөр шалгарсан.

Хонь, тэмээний ноос бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам шинэчлэгдсэнтэй холбогдуулан программд өөрчлөлт оруулж, 2019 онд бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан малчин өрхийн мэдээллийн тулгалтыг хийлээ.

Мөн 2019 бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан 343 өрхийн 55763 ш арьс, ширэнд урамшуулал олгуулахаар мэдээллийг цахим санд оруулж дууссан.

Хүнсний хангамж, нөөцийн судалгаа сумдаас 7 хоног бүр авч нэгтгэж байна. 30 хоногийн хүнсний нөөц бүрдүүлэх гэрээг 6 аж ахуйн нэгжтэй байгуулж, махны нөөц бүрдүүлсэн 3 иргэн, 7 аж ахуйн нэгжид, томоохон супермаркетуудад нөөцийг дотооддоо хэрэглэх, үнийг нэмэгдүүлэхгүй байх, хадгалагдаж буй хүнсний чанар, аюулгүй байдлыг хангаж, хамтран ажиллах талаар зөвлөмж хүргүүлээ. Уг зөвлөмжийг бусад хүнсний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд хүргэх, социалд байршуулан мэдээллийг нийтэд хүртээмжтэй байхад анхааран ажиллаж байна.

**Аймгийн төвийн захууд, томоохон худалдааны төвүүдийн хүнсний бараа бүтээгдэхүүний үнийг өнгөрсөн сарын үнэтэй харьцуулан гаргасан 2020 оны 02-р сарын үнийн мэдээ**

Зах зээлд худалдаалагдаж буй Үхрийн /ястай, цул/ махны үнэ 500 төгрөгөөр, хонины мах /ястай/ 500 төгрөгөөр төмс 250 төгрөгөөр зарим хүнсний ногооны үнэ өнгөрсөн сараас 50-200 төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Бусад бараа бүтээгдэхүүний үнэ тогтвортой байна.

№	Бараа бүтээгдэхүүн		Дээд үнэ төг	Доод үнэ төг	Өссөн буурсан
1	Үхрийн мах	ястай	8500	6000	+500
		цул	12000	10000	+500
2	Хонины мах	ястай	6500	6000	+500
		цул	10000	9500	+500
3	Адууны мах	ястай	6500	5000	-
		цул	9500	9000	-
4	Ямааны мах	ястай	5000	4000	
		цул	8000	7500	-
5	Тахианы мах	гуя	8500	8500	
		мөч	9200	8500	
6	Лууван	монгол	2000	1500	-
		хятад			
7	Төмс	монгол	1200	850	+250
		хятад			
8	Байцаа	монгол	1500	1200	
		хятад			-
9	Чинжүү	монгол			-
		хятад	7000	6800	
10	Манжин	монгол	1200	1200	+50
		хятад			-
11	Сонгино бөөрөнхий	монгол	2000	1600	-
		хятад	1600	1200	-
12	Улаан лооль	монгол	6000	5500	-

13	Өргөст хэмх	монгол	3500	3000	-
14	Элсэн чихэр	монгол	2100	1800	-
15	Будаа	цагаан будаа задгай кг	2500	2000	-
		шар будаа слава кг	3100	2900	-
		гурвалжин будаа кг	3800	2200	-
16	Сүү	задгай	2000	1500	-
		сүү ХХК 0,5л			
		сүү ХХК 1л	3000	2950	-
17	Тараг	задгай	2500	2000	-
		сүү ХХК 1л цөцгийтэй тараг	5000	4000	
18	Талх	Чойр талх	8000	7500	-
19	Өндөг	ОХУ	8500	8500	
		Монгол	9200	8500	
20	Алтан тарианы гурил	задгай дээд	2000	1500	-
		задгай 1-р зэрэг			
		задгай 2-р зэрэг	1200	850	+250
		савласан д/дээд /			
		савласан дээд	1500	1200	
		савласан 1-р зэрэг			-
21	Ургамлын тос	олейна	7000	6800	
		алтан	1200	1200	+50
		алейка			-
22	Гоймон	а/тариа савхан	2000	1600	-

### **ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

**Байгаль орчны чиглэлээр:** Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас Монгол орон даяар 2019 оны 08 дугаар сарын 01-ээс 2020 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн хооронд зохион байгуулагдаж буй “Хоггүй цэвэрхэн Монгол” аяны хүрээнд тахилга шүтлэгтэй газар уул овоог цэвэрлэх арга хэмжээг зохион байгууллаа. Тус арга хэмжээгээр аймгийн түүх, соёлын өв /Цагаан дарь эх, Хүүхдийн овоо, Дагвасүндэл бурхан/-ийг сэргээж, ойр орчмын хог хаягдлыг цэвэрлэсэн.

Мөн улсын тусгай хамгаалалттай “Чойрын богд” ууланд нутагшсан аргаль хонинд зориулан нэмэлт өвс тэжээл, хужир тавьж өгөх /биотехник/ арга хэмжээг Шивээ Овоо ХК-ийн дэмжлэгтэйгээр Байгаль орчин, аялал жуулчлалын газар, байгалийн нөөцийн хамтын нөхөрлөлийн гишүүдтэй хамтран зохион байгуулж, 34 боодол өвс, 0.7 тонн хужрыг бэлтгэн 6 байршилд тараасан.

Аргаль хонины хувьд өвөлжилтийн байдал харьцангуй хэвийн байгаа боловч ойр орчмын малын бэлчээрийн талхагдлын улмаас хаваржилт хүндрэх шинжтэй байна.

Ус цаг уур орчны шинжилгээний төвөөс 02 дугаар сард 8 хугацааны мэдээг нийт 232, Хөдөө аж ахуйн тойм, 10 хоногийн тойм мэдээг нийт 3 удаа, сарын тойм мэдээг 1 удаа тус тус дамжуулсан.

Энэ сард агаар бохирдуулагч элементүүд болох азотын давхар исэл (NO<sub>2</sub>), хүхэрлэг хийн давхар ислийг (SO<sub>2</sub>) хоногт 3 удаа нийт 30 сорьцыг авч, 2 дугаар сарын 1-13-ны өдрүүдийн дээжинд шинжилгээ хийсэн ба шинжилгээний дүнгээр дундажлахад азотын давхар исэл (NO<sub>2</sub>) 0.018 сарын хүлцэх агууламж хэмжээ 0.050, хүхэрлэг хийн давхар исэл (SO<sub>2</sub>) 0.018 сарын хүлцэх агууламж хэмжээ 0.050 байгааг харахад хүлцэх агууламжаас давсан бохирдол ажиглагдаагүй байна.

Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогыг 2019 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 3 дугаар сарын 01-ний хугацаанд зохион байгуулж байгаа бөгөөд 02 дугаар сарын 20-ны байдлаар аймгийн хэмжээнд усан халаалттай 31 зуух, ердийн галлагаатай гэр 2224




зуух, 3998 хөдөлгөөнт эх үүсвэр тоологдон мэдээллийн санд бүртгэгдлээ. Одоогоор тооллогын ажил 90 хувьтай хийгдэж байна.

**Тээвэр, авто замын талаар:** Тээврийн хэрэгслийн техникийн үзлэг оношилгоонд 2020 оны 02 дугаар сарын 27-ны байдлаар 251 тээврийн хэрэгсэл хамрагдсан.

Хот хооронд 531 иргэн зорчиж, 76 тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн хийгдэн, ачаа тээвэрлэлтийн 200 замын хуудас олгосон байна.

**Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, хөрөнгө оруулалтын талаар:**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 09 дүгээр тогтоолоор 2020 онд газрын төлбөрийн орлого 200 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөгөө батлагдсан бөгөөд 2 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар аж, ахуйн нэгжээс 59,727,408 төгрөг, 25 иргэнээс 194,388 төгрөг, нийт 60.126.596 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 30 хувьтай байна.



**Худалдан авах ажиллагааны чиглэлээр:** 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу 73 бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулахаас 2020 оны 02 дугаар сарын 25-ны байдлаар 18 ажлыг зарласнаас тендерийн нээлт хийх хугацаа болоогүй 7, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан 4, дахин зарлахаар шийдвэрлэсэн 7 ажил байна.

### **ДОЛОО. СУМ ОРОН НУТГИЙН ТАЛААР**

**Баянтал сум:** Сумын хэмжээнд томуу, томуу төст өвчний өвчлөл, тархалт болон коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулалттай арга хэмжээ авах, бүх байгууллага, айл өрхүүд тогтмол чийгтэй цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэлийг хийх заавар, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг анхааруулж албан байгууллагуудад албан бичгээр хандаж иргэдэд мэдээллийн хэрэгслүүдээр хүргэн ажиллаж байна.

Дэлхийн зөн-Бор-Өндөр ОНХ төслөөс сумын зорилтот бүлгийн 15 өрхөд хүнсний тусламж үзүүлсэн.

Сумын Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төвтэй хамтран айл өрхүүдээр явж корона вирусийн талаарх мэдээ мэдээлэл, зөвлөмж өгч урьдчилан сэргийлэх гарын авлага, тарааж ажилласан

2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар гадны аймаг сумаас отроор 10 малчин өрхийн 9582 толгой мал отроор өвөлжиж байна. Сумын 2 дугаар багийн Засаг дарга болон мал эмнэлгийн байцаагч, эрүүл мэндийн төвийн эрхлэгч нар гадны аймаг, сумаас өвөлжиж байгаа отрын айл өрхүүдээр явж нүүлгэх мэдэгдлийг өгсөн.

**Шивээговь сум:** Сумын онцгой комисс 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр хуралдаж Коронавирусийн халдвараас иргэд олон нийтийг хамгаалах, эрсдлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах зорилгоор суманд үйл ажиллагаа явуулдаг биллъярд, мөсөн коток, РС тоглоомын газрын үйл ажиллагааг түр зогсоож, өдөр бүр эргүүл хийх хуваарь гарган ажиллаж байна.

Иргэдийг коронавирусийн талаарх буруу ташаа мэдээлэлд автахаас урьдчилан сэргийлж үнэн зөв мэдээллийг түргэн шуурхай хүргэж, коронавирусээс урьдчилан сэргийлэх мэдээллийг албан байгууллагуудад албан тоотоор хүргүүлэн ажилласан.

Аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран амны хөндийн үзлэг, эмчилгээг 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс 7 хоногийн хугацаанд зохион байгуулж, үзлэгт нийт 1-2 дугаар ангийн 6 бүлгийн 161 сурагч хамрагдаж, 126 сурагч өвчлөлтэй буюу шүдний өвчлөлийн тархалт 78.6 хувьтай байна. Үүнээс эмчилгээнд хамрагдах шаардлагатай 105 сурагчийг эмчилгээнд хамруулсан.

Малчдын эрүүл мэндийг дэмжих ажлын хүрээнд 2020 оны 02 дугаар сарын 11, 12-ны өдрүүдэд хөдөөгийн багийн 28 малчин өрхийн 84 иргэнийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан коронавирусээс урьдчилан сэргийлэх зөвлөгөө зөвлөмжийг өгч ажиллалаа.

Сумын бэлчээрийн даац хүрэлцэхгүй байгаатай холбогдуулан сумын Засаг даргаар ахлуулсан бүрэлдэхүүн гадны аймаг сумаас отроор яваа өрхүүдээр орж бэлчээр чөлөөлөх мэдэгдэл өгч, малын халдварт болон гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд хамрагдсан байдалд хяналт хийж ажилласан.

Тус сумаас гадны аймаг, сумдад отроор 27 өрхийн 7464 толгой мал оторлож байна. Суманд гадны аймаг, сумдын 10 өрхийн 6857 толгой мал отроор орж ирсэн байна.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/426 дугаар захирамжийн дагуу цэргийн шинэчилсэн бүртгэлийн ажлыг 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс 02 дугаар сарын 10-ны өдрүүдэд зохион байгуулж, сумын хэмжээнд 75.8 хувьтай бүртгэлийн ажлыг хийж гүйцэтгэн тайлан, мэдээг хугацаанд нь хүргүүлсэн.

Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх Хүүхэд залуучуудын хөгжлийн дэд хөтөлбөр, Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн дэд хөтөлбөрийн 2020 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хэлэлцэн баталлаа. Сумын Хүүхэд залуучуудын хөгжлийн дэд хөтөлбөрийг 2020 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулж, нийт 4 зорилтын хүрээнд 21 ажлыг төлөвлөсөн. Мөн сумын Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн дэд хөтөлбөрийг 2020 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2 зорилтын хүрээнд 14 ажлыг төлөвлөсөн.

Сумын Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлөөс санаачлан “Цахимаар шинэлж өвчлөлөөс сэргийлье” фэйсбүүк аяныг эхлүүлж, 16 өрхийн 88 иргэнд маск, гар ариутгагч бүтээгдэхүүн хандивлалаа.

Дэлхийн зөн-Бор-Өндөр ОНХ төслөөс сумын зорилтот бүлгийн 15 өрхөд хүнсний тусламж үзүүлсэн. Мөн Дэлхийн Зөн Бор-Өндөр ОНХөтөлбөрөөс бүтэн өнчин 4 хүүхдэд хувцас, хүнсний бүтээгдэхүүний дэмжлэг үзүүлсэн.

Орчны бохирдлоос шалтгаалсан халдварт өвчлөл тархах эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд үхсэн малын сэг зэмийг устгах ажлыг зохион байгуулсан.

Бүх нийтийн их цэвэрлэгээг 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулж, 14 аж ахуйн нэгж байгууллагын 65 иргэн 2 га талбайд цэвэрлэгээ хийж, 1.5 тн хог хаягдлыг түүж цэвэрлэн төвлөрсөн хогийн цэгт ачиж зайлуулсан.

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын дагуу 2021 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний саналыг нийт 563 иргэнээс цаасаар, 73 иргэнээс цахимаар аваад байна.

**Сүмбэр сум:** 2020 оны ээлжит цэргийн шинэчилсэн тоо бүртгэл 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс 02 дугаар сарын 10-ны өдөр хүртэл үргэлжлэн, бүртгэл сумын хэмжээнд 87 хувьтай явагдлаа.

Дэлхийн Зөн Бор Өндөр 1 ОНХөтөлбөр нь томуу, томуу төст өвчин болон Шинэ төрлийн коронавирусийн халдварын эрсдлээс сэргийлэх ажлын хүрээнд 160 зорилтот өрхөд нийт 20.0 сая төгрөгийн хүнсний яаралтай тусламж, нүүрс олгосон бөгөөд орон гэргүй 5 өрхөд гэр олголоо.

Дэлхийн зөн Бор-Өндөр 1 ОНХөтөлбөртэй хамтран гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 8 өрхийн 21 хүүхдэд 2650,0 мянган төгрөгийн үнэ бүхий дулаан хувцас, хүнсний тусламжийг үзүүллээ.

Шинэ төрлийн коронавирусын халдвар дамжих, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх тухай мэргэжил арга зүйн зөвлөгөөг багийн Засаг дарга нартай хамтран 3 төрлийн мэдээллийг, нийт худалдаа үйлчилгээний 28, нийтийн тээвэр үйлчилгээ эрхлэгч 12 иргэнд хүргэж ажиллалаа.

Өрхийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн газраас хөдөөгийн 3 багийн нийт 78 малчин өрхөөр орж 128 иргэнд тусламж үйлчилгээ үзүүлэн 124550 төгрөгийн үнэ бүхий эм тариагаар үйлчилсэн байна.